



*Empowered lives.  
Resilient nations.*



Британийн  
Элчин Сайдын  
яам



## ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГЫГ САЙЖРУУЛЖ, СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ, СУРГАЛТ ЯВУУЛАХ АЖЛЫН ТУХАЙ.

Тогтвортой хөгжлийн төлөөх хариуцлагатай  
уул уурхайн санаачилга ТББ-г гүйцэтгэх  
захирал Г.Батсайхан

## *БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ТОВЧ:*

- Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачилга 2006 оноос эхлэлтэй.
- 2007 онд хариуцлагатай уул уурхайн тодорхойлолт, 8 зарчмыг олон талт нэгдсэн уулзалтаар хүлээн зөвшөөрч, баталсан.
- Мөн 2007 онд талууд үйл ажиллагаандаа дагаж мөрдөх *Хариуцлагатай уул уурхайн Санаачлагын Тунхаг* бичгийг боловсруулан гаргаж, түүнд 80 гаруй байгууллага, иргэдийн төлөөлөл нэгдэн орж гарын үсгээ зурсан.
- Талууд ХУУ-г монголд хөгжүүлэх үйл хэргийг цаашид авч явах байгууллагыг бий болгох нь зүйтэй гэж үзсэнээр 2007 онд манай байгууллага байгуулагдсан юм



## ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ТОДОРХОЙЛОЛТ:

Бүх холбогдох талууд, ялангуяа нутгийн иргэдийн эрхийг хүндэтгэсэн, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, олон улсын шилдэг туршлагад тулгуурласан, хууль сахих ёсыг дээдэлсэн, Монгол улсад байнгын ашиг орлого оруулж байх, эрдэс баялгийн салбар дахь ил тод, цогц үйл ажиллагааг “Хариуцлагатай уул уурхай” гэж ойлгоно.



## ХУУ-Н 8 ЗАРЧИМ:

- Олон талын оролцоог хангах.
- Ил тод, нээлттэй байх.
- Хуулийг сахин дээдлэх.
- Байгаль орчин, хүний аюулгүй байдлын өмнө хариуцлага хүлээх.
- Ирээдүйн хөгжилд хөрөнгө оруулах.
- Үр өгөөжтэй байх.
- Хүмүүнлэг ёс зүйтэй байх.
- Дэвшилтэт технологид суурилсан байх.



## ҮҮНЭЭС ХОЙШ ЭНД ТОДОРХОЙЛСНЫ ДАГУУ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ТАЛААР БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ТУСГАГДАЖ ЭХЭЛСЭН

- Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлалд
- “Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлогод
- Ашигт малтмалын тухай болон бусад хуулиудад
- Хөгжлийн хөтөлбөрүүдэд г.м



## *ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ:*

- ХУУ-н гарын авлагыг шинэчлэн гаргалаа
- 2016-11-28, 29-ны өдрүүдэд Дундговь аймагт 25 хүнд ХУУ-н сургалт явуулсан
- 2017-1-18, 19-ны өдрүүдэд Өвөрхангай аймагт 30 хүнд ХУУ-н сургалт явуулсан.



# ГАРЫН АВЛАГЫН ОНЦЛОГ.

- Гарын авлага 3 хэсгээс бүтнэ:
  - 1-р хэсэг уул уурхайн талаар ерөнхий ойлголт өгөх
  - 2-р хэсэг ХУУ-н ерөнхий ойлголт,  
зарчмуудыг хэрэгжүүлэх аргачилал
  - 3-р хэсэг ХУУ-г хөгжүүлэхэд төрийн албадын чиг үүрэг
- Анх удаа ХУУ-н зарчмуудыг хэрэгжүүлэхэд УУ эрхлэгчдийн хийх ажлыг аргачлан зааж өгсөн
- Гарын авлага ХУУ-н мэдлэг олгох сургалтанд зориулагдсан
- Гарын авлагыг дагаад сургалтын дэлгэрэнгүй, хураангуй хөтөлбөр гарснаас гадна, сургагч багшийг сургах хөтөлбөрийг боловсруулсан.



## СУРГАЛТУУДЫН ТАЛААР:

- Сургалтанд аймаг орон нутгийн уул уурхайтай холбогдох төрийн албад сум, багийн засаг дарга, иргэдийн хурлын төлөөлөгчид оролцохоос гадна үйлдвэрлэгчид, иргэний нийгмийн байгууллага, уурхай бүхий нутгийн иргэдээс оролцуулсан.
- Сургалт бүрээс гарын авлагын бүтэц агуулга, сургалтын зохион байгуулалт, заах аргыг сайжруулах талаар болон ХУУ-г хөгжүүлэхэд орон нутгийн оролцогчдын санал авах судалгаа хийж, үр дүнг хэрэгжүүлж байсан.





## СУРГАЛТЫН ҮЕД ОРОН НУТГИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДАС ГАРСАН САНАЛААС ОНЦЛОН ХЭЛЭХЭД:

- Оролцогч талууд : Сургалтыг өргөн далайцтай олныг хамруулж явуулах хүсэлт их байв. Гэхдээ тэд бусад оролцогч талуудад энэ сургалтыг их явуулахыг хүсээд байгаа нь содон сонсогдсон.
- Орон нутгийн төрийн албад: Бид орон нутгийн уурхайг хариуцлагатай байлгахад энэ гарын авлагын дагуу шаардлагаа тавиад ажиллах боломжтой юм байна. Гэхдээ энэ маань эрх зүйн баримт бичиг болоогүй нөхцөлд тэр ажлыг хийх боломжгүй гээд ХУУ-н стандартыг дариу гаргахыг хүссэн.

Мөн Дундговь аймагт уул уурхайн лицензтэй байгууллагын хариулагын төвшинг нь тогтоож үзмээр байна. Ер нь бид УУ-н компаниудын сайн эсвэл муу байгааг хэмжих шалгуур байдаггүй байсан чинь одоо бид үнэлэх боломжтой боллоо. Гэхдээ үүнийг хийхийн тулд дээд газраас ямар нэг удирдамж, заавар хэрэгтэй байна гэсэн.



**АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА**

